

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит
ХХК туслах аудитор: Б.Төртүвшин
Утас: 98904888, Цахим хаяг: baunjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.20 № ЧБА - 2023/121/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Соёлын төвийг улсын төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардал, орон нутгийн төсвөөс тогтмол зардал болох байр ашиглалттай холбоотой зардлыг санхүүжүүлсэн байна. Улсын төсвийн дансны үлдэгдлийг буцаан төвлөрүүлэхгүйгээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болгон тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0200200244

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,004,534.00	22,809,193.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	9,211,959.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	9,211,959.00
3121	Төгрөг	00.00	9,211,959.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	9,211,959.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,004,534.00	13,597,234.00
354	Хангамжийн материал	18,004,534.00	13,597,234.00
35410	Бичиг хэргийн материал	980,600.00	980,600.00
35420	Аж ахуйн материал	17,023,934.00	12,616,634.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	241,571,872.23	231,316,880.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	241,571,872.23	231,316,880.88
392	Биет хөрөнгө	240,563,872.23	230,308,880.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	158,993,217.00	158,993,217.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,195,823.00	-19,874,152.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,081,940.00	22,081,940.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,842,695.88	-17,763,084.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,088,679.00	16,088,679.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,322,278.89	-14,478,552.84
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	43,993,320.00	43,993,320.00
39217	Ном	40,767,514.00	41,267,514.00
393	Биет бус хөрөнгө	1,008,000.00	1,008,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,008,000.00	1,008,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	259,576,406.23	254,126,073.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	259,576,406.23	254,126,073.88
51	Засгийн газрын хувь оролцоо	259,576,406.23	254,126,073.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	62,733,017.00	62,733,017.00
51101	Өмч: - төрийн	62,733,017.00	62,733,017.00
512	Хуримтлагдсан үр дүн	108,366,801.76	102,916,469.41
51210	Өмнөх үеийн үр дүн	108,366,801.76	108,366,801.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-5,450,332.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,476,587.47	88,476,587.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	259,576,406.23	254,126,073.88

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	95,351,100.00	108,146,979.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	82,753,279.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	82,753,279.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	82,753,000.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	00.00	279.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	95,351,100.00	25,393,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,236,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,436,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	95,351,100.00	22,157,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,351,100.00	22,157,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	101,285,872.36	113,597,311.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,285,872.36	113,597,311.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,899,578.47	110,579,790.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,440,074.00	63,031,696.00
210101	Үндсэн цалин	51,522,244.00	48,931,588.00
210102	Нэмэгдэл	00.00	9,126,642.00
210104	Урамшуулал	00.00	3,293,466.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,917,830.00	1,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,327,265.11	8,089,245.00
210201	Тэтгэврийн даатгал	5,067,245.91	5,500,498.58
210202	Тэтгэмжийн даатгал	568,902.30	646,035.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	455,126.18	518,777.20
210204	Ажилгүйдлийн даатгал	111,258.12	129,424.57
210205	Эрүүл мэндийн даатгал	1,124,732.60	1,294,508.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,789,754.00	16,690,458.00
210301	Гэрэл, цахилгаан	445,754.00	346,458.00
210302	Түлш, халаалт	16,344,000.00	16,344,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,311,568.00	2,010,900.00
210401	Бичиг хэрэг	485,850.00	471,500.00
210402	Тээвэр, шатахуун	380,500.00	1,115,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	170,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,295,218.00	253,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	7,560,000.00
210604	Урсгал засвар	00.00	7,560,000.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	692,000.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	692,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,230,113.00	1,750,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	1,750,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	00.00
210807	Газрын төлбөр	14,113.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,700,804.36	10,754,991.35
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,700,804.36	10,754,991.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,386,293.89	3,017,521.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	279.00
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,386,293.89	3,017,242.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,386,293.89	3,017,242.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,934,772.36	-5,450,332.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	289,536.16	00.00

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	289,536.16	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-289,536.16	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-6,224,308.52	-5,450,332.35

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	95,351,100.00	108,146,979.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	82,753,279.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	82,753,279.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	82,753,000.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	00.00	279.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	95,351,100.00	25,393,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,236,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,436,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	95,351,100.00	22,157,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,351,100.00	22,157,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	95,351,100.00	98,435,020.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,351,100.00	98,435,020.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,964,806.11	95,417,499.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,440,074.00	63,031,696.00
210101	Үндсэн цалин	51,522,244.00	48,931,588.00
210102	Нэмэгдэл	00.00	9,126,642.00
210104	Урамшуулал	00.00	3,293,466.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,917,830.00	1,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,327,265.11	8,089,245.00
210201	Тэтгэврийн даатгал	5,067,245.91	5,500,498.58
210202	Тэтгэмжийн даатгал	568,902.30	646,035.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	455,126.18	518,777.20
210204	Ажилгүйдлийн даатгал	111,258.12	129,424.57
210205	Эрүүл мэндийн даатгал	1,124,732.60	1,294,508.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,789,754.00	16,690,458.00
210301	Гэрэл, цахилгаан	445,754.00	346,458.00
210302	Түлш, халаалт	16,344,000.00	16,344,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,594,600.00	2,113,600.00
210401	Бичиг хэрэг	420,000.00	471,500.00
210402	Тээвэр, шатахуун	380,500.00	1,115,600.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	170,000.00
210404	Ном, хэвлэл	498,300.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	356,500.00
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,983,000.00	1,060,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	9,600,000.00	560,000.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	692,000.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	692,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,113.00	3,640,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	3,640,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	00.00
210807	Газрын төлбөр	14,113.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,386,293.89	3,017,521.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	279.00
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,386,293.89	3,017,242.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,386,293.89	3,017,242.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	9,711,959.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-500,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	9,211,959.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	9,211,959.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	61,725,017.00	47,309,385.00	143,046,715.99	00.00	252,081,117.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,725,017.00	47,309,385.00	143,046,715.99	00.00	252,081,117.99

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,082,024.43	00.00	-15,082,024.43
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	62,733,017.00	88,476,587.47	108,366,801.76	00.00	259,576,406.23
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	62,733,017.00	88,476,587.47	108,366,801.76	00.00	259,576,406.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	62,733,017.00	88,476,587.47	108,366,801.76	00.00	259,576,406.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,450,332.35	00.00	-5,450,332.35
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	62,733,017.00	88,476,587.47	102,916,469.41	00.00	254,126,073.88

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,253,000.00	74,341,320.00	11,911,680.00	86%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,253,000.00	74,341,320.00	11,911,680.00	86%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,485,000.00	74,341,320.00	11,143,680.00	87%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,121,400.00	59,186,857.00	2,934,543.00	95%
210101	Үндсэн цалин	59,366,600.00	46,907,935.00	12,458,665.00	79%
210102	Нэмэгдэл	2,754,800.00	8,985,456.00	-6,230,656.00	326%
210104	Урамшуулал	0.00	3,293,466.00	-3,293,466.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,765,100.00	7,608,363.00	156,737.00	98%
210201	Тэтгэврийн даатгал	5,280,300.00	5,173,687.38	106,612.62	98%
210202	Тэтгэмжийн даатгал	621,200.00	608,668.57	12,531.43	98%
210203	ҮОМШӨ-ний даатгал	497,000.00	486,934.84	10,065.16	98%
210204	Ажилгүйдлийн даатгал	124,200.00	121,733.73	2,466.27	98%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,242,400.00	1,217,338.48	25,061.52	98%

2104	Хангамж, бараа материалын зардал	3,449,000.00	2,613,600.00	835,400.00	76%
210401	Бичиг хэрэг	472,100.00	471,500.00	600.00	100%
210402	Тээвэр, шатахуун	1,630,900.00	1,115,600.00	515,300.00	68%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700,200.00	170,000.00	530,200.00	24%
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00	0.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	356,500.00	-210,700.00	245%
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00	0.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	0.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	500,000.00	600,000.00	45%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	500,000.00	600,000.00	45%
2107	Томилолт, зочны зардал	1,133,500.00	692,000.00	441,500.00	61%
210702	Дотоод албан томилолт	1,133,500.00	692,000.00	441,500.00	61%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,116,000.00	3,640,500.00	2,475,500.00	60%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,116,000.00	3,640,500.00	2,475,500.00	60%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,700,000.00	0.00	3,700,000.00	0%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,700,000.00	0.00	3,700,000.00	0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	0.00	768,000.00	0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	0.00	768,000.00	0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	0.00	768,000.00	0%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,253,000.00	800,000.00	85,453,000.00	1%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,753,000.00	0.00	82,753,000.00	0%
310001	Улсын төсвөөс санхүүжих	82,753,000.00	0.00	82,753,000.00	0%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,500,000.00	800,000.00	2,700,000.00	23%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	300,000.00	2,700,000.00	10%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00	0.00	100%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	9,211,959.00	-9,211,959.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100%

610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.00	5.00	0.00	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	0.00	100%

2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,157,700.00	19,140,458.00	3,017,242.00	86%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,157,700.00	19,140,458.00	3,017,242.00	86%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,157,700.00	19,140,458.00	3,017,242.00	86%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,680,000.00	1,680,000.00	0.00	100%
210105	Гэрээт ажлын хөлс	1,680,000.00	1,680,000.00	0.00	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,000.00	210,000.00	0.00	100%
210201	Тэтгэврийн даатгал	142,800.00	142,800.00	0.00	100%
210202	Тэтгэмжийн даатгал	16,800.00	16,800.00	0.00	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,600.00	13,440.00	160.00	99%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,200.00	3,360.00	-160.00	105%
210205	Эрүүл мэндийн даатгал	33,600.00	33,600.00	0.00	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,195,600.00	16,690,458.00	505,142.00	97%
210301	Гэрэл, цахилгаан	851,600.00	346,458.00	505,142.00	41%
210302	Түлш, халаалт	16,344,000.00	16,344,000.00	0.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,072,100.00	560,000.00	2,512,100.00	18%
210604	Урсгал засвар	3,072,100.00	560,000.00	2,512,100.00	18%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,157,700.00	22,157,700.00	0.00	100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,157,700.00	22,157,700.00	0.00	100%
320001	Орон нутгийн төсвөөс	22,157,700.00	22,157,700.00	0.00	100%

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2.00	2.00	0.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1.00	1.00	0.00	100%
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	0.00	100%

2.7 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,435,721.00	(2,435,721.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,435,721.00	(2,435,721.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,435,721.00	(2,435,721.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,164,839.00	(2,164,839.00)
210101	Үндсэн цалин		2,023,653.00	(2,023,653.00)
210102	Нэмэгдэл		141,186.00	(141,186.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		270,882.00	(270,882.00)
210201	Тэтгэврийн даатгал		184,011.20	(184,011.20)
210202	Тэтгэмжийн даатгал		20,567.20	(20,567.20)
210203	ҮОМШӨ-ний даатгал		18,402.36	(18,402.36)
210204	Ажилгүйдлийн даатгал		4,330.84	(4,330.84)
210205	Эрүүл мэндийн даатгал		43,570.40	(43,570.40)
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж			0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,435,721.00	(2,435,721.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,435,721.00	(2,435,721.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,435,721.00	(2,435,721.00)
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөхмөрөн сумын Соёлын төв нь төсвийн хөрөнгийг нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай зарцуулдаг байдлыг хангуулах үйл ажиллагаа явуулдаг юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,450.3 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	9,211.9	9,211.9
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	18,004.5	13,597.2	-4,407.3
Үндсэн хөрөнгө	241,571.8	231,316.8	-10,254.9
Нийт хөрөнгө	259,576.4	254,126.0	-5,450.3
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	259,576.4	254,126.0	-5,450.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	259,576.4	254,126.0	-5,450.3

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 9,211.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,597.2 мянган төгрөг болж 4,407.3 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 231,316.8 мянган төгрөг болж 10,254.9 мянган төгрөгөөр буурсан буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 254,126.0 мянган төгрөг болж 5,450.3 мянган төгрөгөөр буурсан нь тайланд үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 95,351.1 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны /80101/ зардлыг 10,777.8 мянга, урлаг уран бүтээл хийлгэх /80214/ зардлыг 1500.0 мянга, ажил олгогчоос олгох тэтгэм, шагнал урамшууллын /80802/ зардлыг 518.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 108,146.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 108,146.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 83,553.0 мянга, орон нутгийн төсвөөс 22,157.7 мянга, нэмэлт санхүүжилтээр 2,436.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95,917.7 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 12,229.2 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	82,221.2	73,777.3	9,212.0	97.8%
2	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	20,267.7	17,250.4	3,017.2	85.1%
3	Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	0.0	0.0	0.0	0.0%
4	Нийтлэг үйлчилгээний зардал /80112/	1,890.0	1,890.0	0.0	100.0%
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал /80802/	768.0	0.0	0.0	0.0%
6	Уран бүтээл хийлгэх /80214/	3,000.0	3,000.0	0.0	100.0%

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь албан хаагчид өвчтэй, цалингүй чөлөөтэй байсан зэргээс шалтгаалан 2,934.5 мянга, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 156.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 2,475.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 768.0 мянга, Дотоод албан томилолт 441.5 мянга, хангамж, бараа материал зардал 1,153.0 мянга, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 600.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,700.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2,436.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт ирснийг Соёлын төвийн үйлчлэгчийн цалин олгоход зардлаас зарцуулжээ.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Бөхмөрөн сумын Соёлын төв нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн туслах аудитор Б.Төртүвшин гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 113.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 113.5 сая төгрөгийн 1 хувиар буюу 1.1 сая төгрөгөөр 80 хувиар тооцож 0.8 сая төгрөгөөр тогтоолоо.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бөхмөрөн сумын Соёлын төв нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.
/АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 147, хугацаа хоцроож 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Бөхмөрөн сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнө оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бөхмөрөн сумын Соёлын төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ~~холбогдох~~ ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ТУСЛАХ АУДИТОР



М.БАТСУУРЬ/

М.БАТ-АМГАЛАН/

/Б.ТӨРТҮВШИН/

2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр